



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 04 өдөр

Дугаар A/67

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн ХЭГ/02 албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу “Ахмадын үндэсний чуулган”-д оролцогчдод зориулж 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

